

**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Санхүүгийн болон үйл ажиллагааны 7  
тайлан батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дугаар сарын 30-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2023 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоолыг танилцуулсныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



М.ОТГОНБААТАР



**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

┌ Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай ┐

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, дахь заалт болон “ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Д.Уламбаяр
2. Т.Оюунбаатар
3. Г.Ваанчий
4. Н.Баярбат
5. Ж.Жаргалсайхан
6. Б.Мөнхтуяа

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Э.Мөнхзул
2. С.Батсайхан
3. Х.Бат-Очир

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



М.ОТГОНБААТАР



**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

┌ Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай ┐

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.2, 88 дугаар зүйлийн 88.1, 88 дугаар зүйлийн 88.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.10 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаас гаргасан шийдвэр, компаниас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бизнесийн төслийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 баг, Буяннэмэхийн өргөн чөлөө, 2 дугаар гудамж, 200 тоотод байрлах, 947,86 мкв талбайтай Худалдаа үйлчилгээний зориулалттай барилга /Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээний бүртгэлийн дугаар 00774552, Улсын бүртгэлийн дугаар Ү 0814000781/

- Дундговь аймгийн засаг даргын 2008 оны 03 дугаар сарын 11 өдрийн 117/2 тоот захирамжтай Дундговь аймгийн Сайнцагаан сум 7 баг, Буяннэмэхийн өргөн чөлөө-2т байрлах, Худалдаа нийтийн үйлчилгээний зориулалттай 0,04 га бүхий эзэмших эрхийн газар / гэрчилгээний дугаар 000005024, нэгж талбарын дугаар 4809006725, эрхийн улсын бүртгэлийн дугаар Э-0814000406/

-Дундговь аймаг, Дэлгэрцогт сум, Бага газрын чулууны ууланд байрлах 3000 мкв бүхий жуулчны бааз /Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээний бүртгэлийн дугаар 0077446, Улсын бүртгэлийн дугаар Ү-0815000962/ зэрэг компанийн үл хөдлөх хөрөнгүүдийг худалдах гэрээ байгуулах, хөрөнгө шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй.

2. Энэхүү хэлцэл нь их хэмжээний хэлцэл болохыг тэмдэглэсүгэй.

3. Үл хөдлөх хөрөнгийг худалдах хэлцэл хийхтэй холбогдон Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох зөвшөөрөл авах, хэлцлийг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх шилжсэнийг Улсын бүртгэлд бүртгүүлэх ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлж, Төлөөлөн удирдах зөвлөл болон олон нийтэд тайлагнахыг гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



М.ОТГОНБААТАР



**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

┌ Компанийн оноосон нэр өөрчлөх болон үйл ажиллагааны чиглэл өөрчлөх ┐

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, дахь заалт болон “Өлзий дундговь” ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн албан ёсны оноосон нэрийг монголоор “ТНГР эй ай” ХК, англиар “TNGR AI” joint stock company болгон өөрчилсүгэй.
2. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг дараахь чиглэлүүдээр өөрчилсүгэй.
  1. 62090 - Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
  2. 58200 - Программ хангамжийн үйл ажиллагаа
  3. 82190 – Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
3. Компанийн оноосон нэрний өөрчлөлт болон үйл ажиллагааны чиглэлийг компанийн дүрмэнд бүртгэн өөрчлөлтийг холбогдох байгууллагад мэдэгдэн, СЗХ-ноос зөвшөөрөл авч Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



М.ОТГОНБААТАР



**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН  
КОМИССЫН ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар № 1

Улаанбаатар хот

┌ Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай ┐  
болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Монголын улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 74 584 ширхэг хувьцаа эзэмшдэг 3 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр, 0 хувьцаа эзэмшигч итгэмжлэлээр оролцож нийт гаргасан энгийн хувьцааны 74 584 ширхэг буюу 78,09 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 74 584 ширхэг буюу 78.09 хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

КОМИССЫН ДАРГА



Г.ГАНЗОРИГ



**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИССЫН  
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02


Улаанбаатар хот

┌ Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай ┐

Монгол улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 дах заалт, санал хураах хуудсаар өгсөн саналыг тоолсон дүнг хэлэлцээд **ТОГТООХ НЬ:**

№	Хурлаас гарах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлзсэн
1.	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;	74 584 ширхэг буюу 100%		
2	Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах	74 584 ширхэг буюу 100%		
3	Их хэмжээний хэлцэл батлах	74 584 ширхэг буюу 100%		
4	Компанийн оноосон нэр өөрчлөх	74 584 ширхэг буюу 100%		
5	Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх	74 584 ширхэг буюу 100%		
6	Компанийн дүрэм өөрчлөх	74 584 ширхэг буюу 100%		
7.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох			
	1. Д.Уламбаяр	Кумуляти в аргаар сонгох ТУЗ-ийн ердийн гишүүд	74 584 ширхэг буюу 100 %	
	2. Т.Оюунбаатар		74 584 ширхэг буюу 100 %	
	3. Г.Ваанчий		74 584 ширхэг буюу 100 %	
	4. Н.Баянбат		74 584 ширхэг буюу 100 %	
	5. Б.Мөнхтуяа		74 584 ширхэг буюу 100 %	
	6. Ж.Жаргалсайхан		74 584 ширхэг буюу 100 %	
	1. Э.Мөнхзул	Кумуляти в аргаар сонгох ТУЗ-ийн хараат бус гишүүд	74 584 ширхэг буюу 100 %	
	2. С.Батсайхан		74 584 ширхэг буюу 100 %	
	3. Х.Бат-Очир		74 584 ширхэг буюу 100 %	

КОМИССЫН ДАРГА



Г.ГАНЗОРИГ